

**БАЯН-ӨНДӨР СУМЫН 2022 ОНЫ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААРХ НИЙТИЙН СОНСГОЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2023.10.25.

Баян-Өндөр сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын талаарх сонсголыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 10:25 цагт Хүүхдийн ордонд эхэлж, Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат нээв.

Сонсголд Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат, Засаг дарга Б.Баасансүрэн, Засаг даргын орлогч Ж.Энхсайхан, Тамгын газрын дарга Ш.Өлзийбаяр, ЗДТГ-ын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн П.Даваажаргал, ажиглагчаар “Эрдэнэт-Хүмүүн” ТББ-ын төлөөлөл н.Батцэцэг, Баян-Өндөр сумын хуулийн мэргэжилтэн Д.Эрдэнэсүх болон 26 багийн иргэдийн төлөөлөл 100 иргэн оролцов.

Сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат сонсголын дэгийг танилцуулав.

**ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** -Сонсголын дэгтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх иргэн байна уу?

**ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** -Байхгүй байна. Дэгээ батлах уу?

-Оролцогчдын 100 хувийн саналаар сонсголын дэгийг батлав.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

**1.Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл хийв. *Илтгэгч нь Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн / Тэмдэглэлд тайланг хавсаргав./***

**Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:**

Ер нь манай Баян-Өндөр сум Монгол Улсынхаа хэмжээнд хүн амын тоо, дэд бүтэц, нягтаршил зэргээрээ тэргүүнд явдаг, МУ-ын хэмжээнд хамгийн том сум, тэгсэн хэрнээ төсөв хуваарилалтын хувьд манайх төдийлөн хангалттай биш байдаг, анх удаа бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 730,5 сая төгрөг ирж байсан, 2022 онд бид бүхэн аймаг орон нутгийнхаа удирдлагуудтай зөвшилцөж ярилцсаны хүрээнд 2,7 тэрбум төгрөгний орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахаар болсон. Дээр нь сум, орон нутгийн хэмжээнд ажлуудыг чанартай зохион байгуулах, үр дүнд нийцүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслүүдийг хууль, дүрэм журмын дагуу гүйцэтгэсэн тохиолдолд урамшуулал олгогддог. 2021 онд урамшуулал байгаагүй, 2022 онд урамшууллын 250,0 орчим сая төгрөг, 2023 онд 500,0 орчим сая төгрөгийн урамшуулал авч чадсан. Орон нутгийн хэмжээнд төсвийн байгууллага буюу манай Баян-Өндөр суманд өөрсдийнхөө төсвийг бүрдүүлэх төрийн сангийн салбар, нэгж байхгүй байсан, энийг бид холбогдох байгууллагын удирдлагуудтай хуулийн дагуу ярилцаж, зөвшилцсөний үндсэн дээр Төрийн сангийн хэлтсийг хажуудаа татаж

авсан. Ингэснээр орон нутагт төвлөрүүлэх төсөв, орлого бүрдүүлэх ажлуудаа өөр дээрээ гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар Баян-Өндөр сум үндсэндээ 104,0 орчим тэрбум төгрөгийг аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. Төрийн сантай болсноор Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын хэмжээ нэмэгдэж ирж байгаа, мөн төсөв бүрдүүлэлтийн болон төсөв хуваарилалтын хэмжээ хүн ам өсөж байгаатай холбогдуулан нэмэгдэж ирж байгаа. 2022 онд 55 ажил, арга хэмжээг 2,702,200 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж ажилласан байдаг. Энэ ажил, арга хэмжээг Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн танилцууллаа.

**Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** - Асуулт, саналаа нэгтгээд явъя, асуулттай, саналтай хүмүүс байна уу?

**ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** –Баян-Өндөр сумын ИТХ-ын төлөөлөгч, /Яргуйт, малчин багаас сонгогдсон/ Ц.Отгонбаяр байна.

**Баян-Өндөр сумын ИТХ-ын төлөөлөгч Ц.Отгонбаяр:** -Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгийн зарцуулалтын талаарх сонсгол хийж байгаатай холбогдуулан асууя. ОНХС-ийн 2022 оны зарцуулалтанд хуулиндаа Аудитын шалгалт орсон байх ёстой. Аудитын шалгалтаар ямар зөрчил илэрсэн, хэрэв гарсан бол хэрхэн шийдвэрлэсэн бэ?

**Сумын ЗДТГ-ын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн:**  
**П.Даваажаргал:** –Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэнд хүргэе. Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Даваажаргал байна. 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтанд хийсэн Аудитын дүгнэлтээр зөрчилгүй, зөвлөмжтэй шалгагдсан байгаа. Зөвлөмж нь иргэдээс гарсан санал, эдгээр саналаас дэмжигдээгүй 2 санал байсан, тэрэнд зөвлөмж гарсан, энэ нь Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлууд байсан.

**Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн:** -Жил бүрийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтанд төрийн болон хөндлөнгийн байгууллагын Аудитын шалгалт ордог. 2021, 2022 онуудын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтанд хязгаарлалттай дүгнэлт буюу хийж хэрэгжүүлсэн ажил дээр буруу ажил хийсэн алдаа дутагдал гарсан зүйл байхгүй, зөвлөмжийг 2-3 ажил дээр өгсөн байна. Энэ нь Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлууд болон Ковидтой холбоотой зарим нэг ажлууд дээр гарсан, энэ ажлаа 2023, 2024 оныхоо төсөв дээр тусгах тал дээр ажил хэрэг болгоорой, мөн иргэддээ сайн танилцуулж ажиллаарай гэдэг зүйлийг зөвлөмжөөр ирүүлсэн байгаа.

**Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** -Санал шүүмжлэл байхгүй гэж ойлголоо. Санал шүүмжлэлгүй байна гэдэг бол их хэцүү эсвэл нэг талдаа маш сайн ажилласан гэж ойлгож байгаа, нөгөө талдаа хүмүүс маань ямар ч ойлголт мэдээлэл авахгүй байна гэсэн 2 талтай байна. Санал шүүмжлэлээ сайн гаргавал бид бүхэн цаашдынхаа ажилдаа тусгаад, алдаа оноогоо сайжруулаад явъя гээд та бүгдээсээ санал, хүсэлт сонсмоор байна. Гэхдээ аймгийн Засаг дарга, орон нутгийн хэлтэс агентлагууд маань бүх багуудаар тойрч иргэдтэй уулзалт хийж байна, иргэдийн саналыг сонсож, аймаг, орон нутгийнхаа ажлын тайлангуудаа тавиад явж байгаа. Тэр уулзалтанд Баян-Өндөр сумын Засаг дарга тогтмол оролцож

байгаа.Тэнд иргэдээс санал, шүүмжлэлүүд гарч байна. Энэ онуудад Орон нутгийн хөрөнгөөр суманд хийгдэж байгаа бас нэг гол ажил гэх юм бол 3,8 тэрбум төгрөгний хөрөнгөөр 150 хүүхдийн Цэцэрлэгийг орон нутагтаа анх удаа сумын хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулж байгаа. 2016-2020 онд Рашаант, Уртын гол, Цагаанчулуут багийн хүүхдүүд суралцах 140 хүүхдийн Цэцэрлэгийг аймгийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулсан. Энэ удаад сумынхаа хөрөнгөөр 150 хүүхдийн Цэцэрлэгийг барих ажлыг бүрэн шийдвэрлэсэн. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн тухайн Цэцэрлэгтэй холбоотой ажилчин, албан хаагчид болон бусад урсгал зардлууд бүх зүйл нь Боловсролын яам дээр суугдаад шийдвэрлэгдэх учраас 2024 оны 1-р сарын 1-нээс Цэцэрлэг ашиглалтанд орохоор болж байгаа энэ асуудлыг та бүхэнд дуулгахад таатай байна.

**Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** -За асуулт санал, хүсэлт байхгүй байна гэж ойлголоо.

**Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн:** -2021 оноос Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд өөрчлөлт ороод Монгол Улсын 330 сум бие дааж хөгжих боломжийг нээсэн. МУ-ын төсвийг 21 аймгаас 6 аймаг бүрдүүлж байгаа. Үүний дотор манай Орхон аймаг 160,0 тэрбум төгрөгийг 2023 онд төвлөрүүлж байгаа. Сум бие дааж хөгжих боломжийг нээж өгсөн хуулийн зохицуулалтаар бол хүн амын орлогын албан татвар, газрын төлбөр хураамж гээд олон зүйлүүд тухайн сумандаа орлого болж үлдэх ёстой байдаг боловч манай аймаг 160,0 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүрэг хүлээгээд үүнээс Баян-Өндөр сум 106,0 тэрбум төгрөгийг аймагт төвлөрүүлээд, аймаг шууд улсын төсөвт тэгшитгэж байгаа. Энэ ажлын хүрээнд бид 106,0 тэрбум төгрөгийг 9-н сарын байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй, зарим нэг үзүүлэлтээр давсан орлого бүрдүүлээд явж байна. Жилдээ манай сум 22,0 тэрбум төгрөгийг газрын төлбөр, хураамж гээд сумын ИТХ-аараа батлуулдаг, үүнийгээ аймагт төвлөрүүлдэг. Бид аймгийн Татварын хэлтэстэй нягт уялдаа холбоотой ажилладаг, тухайн байгууллагын ажилчин, албан хаагчид орлого бүрдүүлэх ажил дээр үр дүнтэй сайн ажиллаж байгаа. Мөн манай Баян-Өндөр сумын багууд дунджаар 1500-1600 өрхтэй, 5000-5500 хүн ам оршин суудаг, Булган аймгийн нэг сум гэхэд 800 өрхтэй, 3000 хүн амтай байдаг жишээний, тэгэхээр манай багууд 2-3 сумын дайтай хүн амд төрийн үйлчилгээ хүргээд явж байна. Бид хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой ажилчин, албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, өдөр, шөнөгүй ажиллаж байгаа хүмүүсдээ нийгмийн дэмжлэг үзүүлэхэд анхаарч "Төрийн албан хаагч", "Хэсгийн ахлагч" хөтөлбөрүүд болон бусад олон зүйлийг хэрэгжүүлж байна. Энэ маань Бор уулын буян, иргэд оршин суугчдын маань итгэл үзүүлж хамтарч ажиллаж байгаагийн гол үр дүн. Мөн Баян-Өндөр сумын ИТХ-ын 11 төлөөлөгч маань багийн Засаг даргаар давхар ажиллаж, тухайн хурлын хуралдаан дээр тухайн баг дээр юу тулгамдаж байна, иргэд оршин суугчид юу хүсэж байна, санал санаачилга юу гарч ирж байна гээд ил тод нээлттэйгээр ярилцдаг нь давуу тал байдаг. Ингээд сумын ИТХ-ын төлөөлөгчдийг, багийн ажлын албыг байнга дэмжиж хамтран ажилладаг иргэд та бүхэндээ маш их баярладаг шүү, баярлалаа гэж хэлье.

**Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат:** -Ер нь Баян-өндөр сумаас он гаргаад 6 сар хүртэл иргэдийн санал асуулгыг нээлттэй байдлаар авч хэвшил болж байна. Үндсэндээ манай дээр энэ оны түвшинд иргэдийн санал 40 орчим мянган хүний санал ирж байгаа. Хуучин 15 мянган хүний саналаар Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын ажил явдаг байсан бол энэ онд 140 орчим хувь нэмэгдэж, иргэдийн санал асуулга хангалттай, нэг талдаа иргэдийн маань оролцоо маш их сайжирч байна, нөгөө талдаа танхимын уулзалтаар харьцангуй иргэдийн ирэх тоо хязгаартай, цахим санал асуулга эрс нэмэгдсэн. Ингээд асуулт, санал байхгүй байгаа тул сонсголын үйл ажиллагааг хаасныг мэдэгдье.

Сонсголын үйл ажиллагааг 11:20 цагт хаав.

**СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:**

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ДАРГА Э.ЭРДЭНЭБАТ

**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:**

ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ, ИРГЭНИЙ ТАНХИМ, ОЛОН НИЙТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН О.НАРАНБАЯР